

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

**Санамж:** Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавар нийт 76 оноотой. Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай. Амжилт хүсье.

- Адилтгах замаар зөв хариултыг сонгоно уу. (1 оноо)  
**А. Нарийн голын хөндийн бууц суурин - ?**      **Б. Цагаан агуй – 730000 жилийн өмнө**  
 А. 8000 жилийн өмнө      В. 300000 жилийн өмнө  
 С. 40000 жилийн өмнө      D. 12000 жилийн өмнө      E. 800000 жилийн өмнө
- Дээд палеолитын үед холбогдох Ховд аймгийн Буянт сумын нутагт орших Чандмань Хар үзүүрийн хадны зургийг ямар аргаар зурсан бэ? (2 оноо)  
 А. Хийсвэр      В. Зосон      С. Амьтны загварт урлаг      D. Хадны зураг      E. Сийлмэл
- Монгол орны өмнөд, төв, умард нутгуудад хүмүүс газар сууц бүхий суурин байгуулж, удаан хугацаагаар амьдарсан ул мөр аль үед холбогдох вэ? (1 оноо)  
 А. Неолит      В. Палеолит      С. Мезолит      D. Энеолит      E. Хүрлийн үе
- Неолитын үеийн Баянзагийн суурингаас аж ахуйн зориулалттай самбар чулуу, нухуур чулуун багаж олджээ. Үүнд дүгнэлт өгнө үү. (2 оноо)  
 А. Неолитын үеийн чулуун багаж зэвсгүүд том хэмжээтэй байжээ.  
 В. Самбар, нухуур чулууг ашиглаж ан амьтан агнадаг байжээ.  
 С. Үр тариа цайруулж хүнсэндээ хэрэглэдэг байжээ.  
 D. Хүмүүсийн дунд эд хөрөнгө, эрх мэдлийн ялгарал байсан.  
 E. Самбар нухуур чулуугаар эмэгтэйчүүд гоёлын зүйлс хийдэг байсан.
- Хүрэл, түрүү төмрийн үед холбогдох, Евразийн нүүдэлчдийн амьтны загварт урлагийн бүтээлүүдээс онцгой байр суурь эзэлдэг түүхэн дурсгал аль нь вэ? (1 оноо)  
 А. Хиргисүүр      В. Буган хөшөө  
 С. Дөрвөлжин булш      D. Хадны зураг      E. Түүвэр олдвор
- Монголчуудын байгуулсан анхны төрт улс аль нь вэ? (1 оноо)  
 А. Жужан      В. Сяньби      С. Хүннү      D. Хятан      E. Их Монгол улс
- НТӨ IV зуунд хятадын Жао зэрэг ванлигууд нүүдэлчдийн хувцсыг өмсөж, нум сумт морьт цэрэг байгуулжээ. Үүний учир шалтгаан юу вэ? (2 оноо)  
 А. Нүүдэлчид нийгэм эдийн засгийн хөгжлөөр хятадаас илүү учир  
 В. Хятадын Жао ванлиг нүүдэлчдээс цэргийн талаар дутуу учир  
 С. Нүүдэлчид анх нум сум зохиож, дайнд ашиглах болсон учир  
 D. Нүүдэлчдийн амьдралын хэв маяг суурин орнуудад дэлгэрч байсан учир  
 E. Жао ванлиг тагнан турших, шинэ газар нутгийг байлдан эзлэхийн тулд
- Моюнчур хааны үед ямар улс цэцэглэн хөгжсөн бэ? (1 оноо)  
 А. Жужан      В. Түрэг      С. Хятан      D. Уйгур      E. Сяньби
- Эртний улсуудад аж ахуй, цэрэг дайны явдалд чухал үүрэгтэй нь аль вэ? (1 оноо)  
 А. Адуу      В. Бог мал      С. Үхэр      D. Тэмээ      E. Илжиг, луус



10. Гиюй (Лаошан) шаньюйд Хань улсын ордны тайган Жун Хан хүчин зүтгэж байхдаа “Хүннүгийн хүн ам Хань улсын нэг тойрогт хүрэхгүй. Хүчирхэг байгаагийн шалтгаан нь хоол унд, хувцас хунар өөр. Хань улсад түшиглэхгүй учир болой” гэсэн сурвалжийн мэдээ нь ямар утга санааг илэрхийлж байна вэ? (1 оноо)
- A. Хүннү нар Хань улсын хүн амаас цөөн байсан учир хүчирхэг биш байсан.  
 B. Хүннү улс Хань улсад түшиглэдэг байсан учир хүчирхэг байсан.  
 C. Хүннү улс нийгэм, соёлын хувьд бие даасан хүчирхэг улс байсан.  
 D. Хань улсын хүн ам Хүннүгээс олон байсан учир хүчирхэг байсан.  
 E. Хүннү нар Хань улстай хувцас хунар, хоол, идээ ижил байсан.
11. Бурхны шашнаар дамжин эртний Энэтхэгийн төр, шашны хослон барих “хоёр ёс”-ыг аль улсын үеэс дэлгэрч төрийн үзэл суртал болсон бэ? (1 оноо)
- A. Хүннү      B. Сяньби      C. Хятан      D. Түрэг      E. Жужан
12. Монголын эртний улсуудын соёлоос Хүннү улсын үед аль нь холбогдох вэ? (1 оноо)
1. Ахын дуу    2. Эсгий ширдэг    3. 12 жилийн цаг тоолол    4. Их, бага бичиг    5. Хар балгас
- A. 3, 5      B. 1, 2      C. 2, 3      D. 2, 4      E. 1, 5
13. 1147 онд Монголчууд Алтан улстай дайтан ялжээ. Уг оныг зуунд шилжүүлнэ үү. (1 оноо)
- A. XI зууны I хагас      B. XIII зууны I хагас  
 C. XII зууны II хагас      D. XII зууны I хагас      E. XI зууны II хагас
14. “Хоёр наран ургаваас  
 Худгийн усан ширгэюү  
 Хоёр хаан сууваас  
 Хамаг улсаа барьюу” хэмээн ямар сурвалжид тэмдэглэгдсэн бэ? (2 оноо)
- A. Дорно этгээдэд зорчсон тэмдэглэл    B. Монголын нууц товчоо    C. Судрын чуулган  
 D. Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх    E. Лу.Алтан товч
15. Чингис хааны өмнөх үеийн Монголчуудад холбогдох ойлголтыг зөв тохируулна уу. (2 оноо)
1. Нийгмийн зохион байгуулалт      a. Хан, сэцэн, баатар  
 2. Нийгмийн давхраажилт      b. Хүрээ  
 3. Аж ахуй      c. Талын малчин, ойн анчин
- A. 1b 2a 3c      B. 1a 2b 3c      C. 1b 2c 3a      D. 1c 2a 3b      E. 1a 2c 3b
16. Их Монгол улсын үйл хэргийг удирдан явуулах нийт ноёдыг даргалах үүргийг хэнд хариуцуулсан бэ? (1 оноо)
- A. Хубилай    B. Шихихутуг    C. Цагадай    D. Го ван Мухулай    E. Үсүн өвгөн
17. 1219 онд Чингис хаан Хорезм улс руу довтлох болсон шалтгаан юу вэ? (1 оноо)
- A. Эцэг өвгөдийн гэрээсийг биелүүлэх, аюулгүй байдлаа хангасан учир  
 B. Аян дайны үед баруун гар болох холбоотны үүргээ биелүүлээгүй учир  
 C. 450 худалдаачдыг хөнөөж, элчийг хороож доромжилсон учир  
 D. Төрийн эрхэнд гарсан Найманы Таян ханы хүү Хүчүлүгийг дарах учир  
 E. Хорезм улс, Алтан улстай Монголын эсрэг гэрээ байгуулсан учир



18. Чингис хааны Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг ялгана уу. (2 оноо)

1. Их Монгол улсыг байгуулсан
2. Торгоны замын үүрэг өндөр түвшинд хүргэсэн
3. Евразийг дамнасан газар нутагт нэгдсэн дэг журам тогтоосон
4. Мянгатын системийг буй болгов
5. Өрнө, дорнын хооронд худалдаа, соёлын харилцаа хөгжив
6. Хархорум хот дэлхийн нийслэл болох үндэс тавигдав

A. 1, 2, 3      B. 1, 4, 6      C. 3, 4, 5      D. 2, 3, 6      E. 4, 5, 6

19. 1246 онд Тамирын Шар ордонд Гүюгийг хаан өргөмжлөв. Чингисийн хэдэн он бэ? (1 оноо)

- A. Чингисийн 83 он      B. Чингисийн 84 он      C. Чингисийн 85 он  
D. Чингисийн 40 он      E. Чингисийн 57 он

20. Мин улсын их цэрэг Хархорум хотыг хэдэн онд эвдлэн сүйтгэж шатаасан бэ? (1 оноо)

- A. 1374 он      B. 1368 он      C. 1388 он      D. 1380 он      E. 1387 он

21. Мин улс Монголчуудын цэрэглэх чадварыг бууруулах, адуун сүргийн бүтцийг алдагдуулах, өөрсдийн аюулгүй байдлыг хамгаалах, хүчээ зузаатгахын тулд ямар бодлогыг хэрэгжүүлсэн бэ? (2 оноо)

- A. Цэрэглэх чадварыг бууруулах бодлого      B. Жижиг захын бодлого  
C. Шинэ засгийн бодлого      D. Сарын захын бодлого      E. Адуун засгийн бодлого

22. XVII зууны үеийн бие даасан улсуудаас **Цорос, Галдан бошгот, чуулган** зэрэг ойлголтууд нь аль улсад холбогдох вэ? (1 оноо)

- A. Зүүнгарын хаант улс      B. Өвөр Монгол      C. Халхын хаант улс  
D. Хошууд улс      E. Хотгойд улс

23. Халх, Ойрад, Халимаг, Хошуудын эрх баригч 28 ноён язгууртнууд Тарвагатайн Улаан бураа хэмээх газар чуулган чуулж "Их цааз"-ыг хэзээ баталсан бэ? (2 оноо)

- A. 1688 он      B. 1636 он      C. 1640 он      D. 1691 он      E. 1755 он

24. 1586 онд Абтай сайн ханы байгуулсан хийдийг 2004 онд Дэлхийн соёлын өвд бүртгэжээ. Энэ ямар хийд вэ? (1 оноо)

- A. Амарбаясгалант хийд      B. Эрдэнэзуу хийд      C. Манзуширын хийд  
D. Шанхын хийд      E. Хөгнө Тарнын хийд

25. Монголын нийгэмд үзүүлсэн шарын шашны эерэг нөлөөнд аль нь хамааралгүй вэ? (2 оноо)

- A. Энэтхэг, Төвөдийн соёлыг дэлгэрүүлсэн.  
B. Монголчуудыг номхон хүлцэнгүй болгосон.  
C. Бөөгийн хойлголох зан үйлийг халсан.  
D. Оюун санааны хувьд нэгдэх хүчин зүйл болсон.  
E. Нийт ард олны дунд нэвтэрч, зонхилох шашин болсон.



26. XVI-XVII зуунд Монголчуудын зохиосон бичиг үсгийг цаг хугацаагаар нь эхлэлээс төгсгөл рүү зөв эрэмбэлсэн хэсгийг сонгоно уу. (2 оноо)

1. Тод үсэг	2. Соёмбо үсэг	3. Али гали үсэг
-------------	----------------	------------------

A. 1, 3, 2    B. 1, 2, 3    C. 2, 1, 3    D. 3, 1, 2    E. 3, 2, 1

27. Манж Чин улсын эрхшээлд орсон Монголын хаант улсуудын эзлэгдсэн оныг зөв ялгасан хэсгийг сонгоно уу. (1 оноо)

Манж Чин улс	1	1727
	2	1636
	3	1755
	4	1771
	5	1691

A. 1, 3, 5    B. 1, 2, 3    C. 1, 4, 5    D. 2, 3, 4    E. 2, 3, 5

28. Лигдэн хаан хатуу засаглалд шилжиж, улс орноо цэргийн хүчээр нэгтгэхийг зорьж байсан нь ямар бодлогод хамаарах вэ? (2 оноо)

A. Дайчин төрөөр нэгтгэх бодлого    B. Тайван төрөөр нэгтгэх бодлого  
C. Шинэ засгийн бодлого    D. Шинэ эргэлтийн бодлого    E. Адуун засгийн бодлого

29. 1607 онд харьяат нараа авч баруун хойш Тоболь голын эхэнд нүүж очсон Ойрадын ноён хэн бэ? (1 оноо)

A. Хо өрлөг    B. Эрдэнэбаатар хунтайж    C. Төрбайх гүүш    D. Санжжав    E. Аюук

30. Сөнөдийн Тэнгис ван харьяатаа дагуулан Халхын Сэцэн хан Шолойг түшихээр хэдэн онд ирсэн бэ? (1 оноо)

A. 1639    B. 1648    C. 1646    D. 1640    E. 1636

31. Галдан хаан Халх улсад довтолсны гол үр дагавар юу вэ? (2 оноо)

A. Халхын хойд нутгийг Хаант Орос улсад алдахад хүргэсэн.  
B. Халх Монголыг Манжид дагаар ороход хүргэсэн.  
C. Халх улсын дотоод хэрэгт Манж Чин улс оролцохоо больсон.  
D. Зүүнгар улсын эдийн засаг, цэргийн хүч чадлыг сулруулсан.  
E. Монголын дотоод хэрэгт Төвөдийн Далай ламыг оролцуулсан.

32. XIX-XX зууны эхэн үеийн Халхын 4 аймгийг газар зүйн байршлаар нь баруунаас зүүн рүү зөв эрэмбэлнэ үү. (2 оноо)

1. Сайн ноён аймаг	2. Түшээт хан аймаг	3. Засагт хан аймаг	4. Сэцэн хан аймаг
--------------------	---------------------	---------------------	--------------------

A. 3, 2, 1, 4    B. 3, 1, 2, 4    C. 2, 3, 1, 4    D. 4, 1, 2, 3    E. 2, 4, 1, 3

33. Монголчууд шинэ засгийн бодлогыг эсэргүүцэх хөдөлгөөн ямар уриан дор өрнөж байсан бэ? (1 оноо)

A. Хятад-Манжаас салах цаг боллоо    B. Харийнхныг зогсоох  
C. Монгол овогтон бүгдээр нийлэх    D. Язгуурын ёсоо журамлах  
E. Тусгаар тогтносон улс болох



34. Дараах үйл явдлыг утгаар нь зөв харгалзуулна уу. (1 оноо)

a	1907 он	1	Өвөр Монгол руу 5 замын их цэрэг илгээв.
b	1912 оны 8-р сар	2	Хайсан, Алмас-Очир нар Хүрээнд ирж Халхын ноёдтой зөвлөлдөв.
c	1913 он	3	Монгол цэргүүд ховдыг чөлөөлөв.

A. a2 b1 c3      B. a1 b2 c3      C. a3 b2 c1      D. a3 b1 c2      E. a2 b3 c1

35. 1911 оны Монгол улсын засгийн газрын сангийн яамны сайд хэн бэ? (1 оноо)

A. Э.Намсрай      B. С.Гомбосүрэн      C. М.Ханддорж      D. Г.Цэрэнчимэд      E. Г.Чагдаржав

36. 1913 онд “Монгол улсын хязгаарын доторх олон зүйлийн уурхайг нээн шийтгэх дүрэм хэмжээ”-г батлав. Дүрэмд зааснаар олборлосон чулуун нүүрсний орлогын хэдэн хувийг татварлах вэ? (1 оноо)

A. 5-10%      B. 10-15%      C. 20-30%      D. 30-60%      E. 20-50%

37. 1921 оны хувьсгалын түүхэн зүтгэлтнүүдийг зөв ялгасан хэсгийг сонгоно уу. (1 оноо)

1921 оны хувьсгалын удирдагчид	1	Т.Намнансүрэн
	2	Д.Чагдаржав
	3	С.Зориг
	4	Д.Бодоо
	5	Хайсан гүн
	6	Ж.Батмөнх

A. 2, 4      B. 1, 3      C. 5, 6      D. 2, 1      E. 1, 4

38. 1921 оны хувьсгалд холбогдох үйл явдлыг он цагийн хувьд зөв дараалалд оруулсныг сонгоно уу. (2 оноо)

1. Нууц бүлгэмүүд байгуулагдав
2. Хиагтыг чөлөөлөв
3. Монгол ардын нам байгуулагдав

A. 1, 2, 3      B. 3, 2, 1      C. 2, 3, 1      D. 1, 3, 2      E. 2, 1, 3

39. 1921 оны намар Толбо нуурт 42 хоног бүслэгдэн байлдсан цэргүүдийг хэн хэн удирдсан бэ? (1 оноо)

A. М.Дугаржав, Ц.Бумцэнд      B. Хатанбаатар Магсаржав  
C. Манлайбаатар Дамдинсүрэн      D. Д.Сүхбаатар, Х.Чойбалсан  
E. Хасбаатар, Дамбадорж

40. Зөвлөлт-Хятадын 15 зүйлт гэрээ бичгийн 5-р зүйлд (1924.5.31) “Зөвлөлт Засгийн газар Гадаад Монгол нь Дундад Иргэн Улсын нэг хэсэг мөн болохыг хүлээн зөвшөөрөх бөгөөд уг нутаг дэвсгэр дэх Хятадын бүрэн эрхийг хүндэтгэнэ” хэмээх сурвалжийн мэдээнд дүгнэлт хийнэ үү. (2 оноо)

- A. Уг гэрээгээр Зөвлөлтийн засгийн газар Хятадтай нийлж Монголын газар нутгийг хувааж өөрийн нөлөөг тогтоосон.
- B. Уг гэрээгээр Зөвлөлтийн засгийн газар Монгол улсыг өөрийн нэг хэсэг гэж үзсэн.
- C. Уг гэрээгээр Монгол улсын тусгаар тогтнолыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх боломжийг хаасан.
- D. Уг гэрээгээр Зөвлөлтийн засгийн газар Монголын тусгаар тогтнолыг Хятадаар зөвшөөрүүлэх бодлого явуулсан.
- E. Уг гэрээгээр Зөвлөлтийн засгийн газар Хятадтай харилцахын тулд Монголыг ашигладаг байсан.



41. Анхдугаар Үндсэн хуулиар улсын нэрийг хэрхэн өөрчилсөн бэ? (1 оноо)  
А. Монгол улс В. Бүгд Найрамдах Монгол ард улс  
С. Олноо өргөгдсөн Монгол улс D. Хэмжээт цаазат Монгол улс  
E. Богд хаант Монгол улс
42. Монгол улс Бүгд найрамдах засаглалд шилжиж, анхдугаар үндсэн хуулиа баталсны 100 жилийн ой хэдэн онд тохиох вэ? (1 оноо)  
А. 2024 он В. 2031 он С. 2040 он D. 2041 он E. 2060 он
43. 1935 онд нийт хүн амын 5,6 хувь нь бичигтэй байсан бол 1940 онд 20,8 хувь болж нэмэгдсэн нь ямар бодлогын үр дүн бэ? (2 оноо)  
А. Шинэ сэргэлтийн бодлого В. Эдийн засгийн үндсэн бодлого  
С. Шинэчлэлийн бодлого D. Шинэ засгийн бодлого E. Шинэ эргэлтийн бодлого
44. Тусгаар тогтнолоо Хятадаар зөвшөөрүүлэх нөхцөлийг хангасан бүх нийтийн санал хураалт хэзээ болсон бэ? (1 оноо)  
А. 1924.11.26 В. 1945.9.21  
С. 1911.12.29 D. 1945.10.20 E. 1921.7.11
45. 1960-1990 онд Монголд улс төрийн ямар дэглэм тогтсон бэ? (1 оноо)  
А. Ардчилсан В. Тоталитар  
С. Авторитар D. Бүгд найрамдах E. Цэргийн
46. 1979 оны МАХН-ын Төв Хорооны тогтоолд "... Хир буртаг өчүүхэн ч хүргэхгүй нандигнан хайрлаж, тахин шүтэж байх зүйл маань нэгдүгээрт нийгмийн өмч, хоёрдугаарт социалист өмчийг цогцлоон бүрдүүлэгч эх үүсвэр болсон ариун цагаан хөдөлмөр мөн" хэмээх сурвалжийн мэдээ түүхэн ямар үйл явдлыг илэрхийлж байна вэ? (1 оноо)  
А. Соёлын довтолгоо В. Намын эсрэг бүлэглэл С. Нэгдэлжих хөдөлгөөн  
D. Сэхээтний төөрөгдөл E. Атрын аян
47. Хүйтэн дайны үеийн сэргэлдэгч талуудад орох улсууд аль нь вэ? (2 оноо)  
**А. Капиталист орнууд- АНУ, Их Британи В. Социалист орнууд- ?**  
А. Голланд, Бельги В. Баруун Герман, Вьетнам  
С. Дани, Умард Солонгос D. Франц, Унгар E. Монгол, Польш
48. Өгөгдлийг ашиглаж зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)  
**(Олноо өргөгдсөний 12 он+Ардын хувьсгалын 73 жилийн ой):2+4=?**  
А. 1945 оны Чөлөөлөх дайн болов. В. 1981 онд Монгол хүн сансарт нисэв.  
С. 1939 оны Халх голын дайн болов. D. 1961 онд Монгол улс НҮБ-д элсэв.  
E. 1976 онд Атрын II аян өрнөв.
49. МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо огцрохоо мэдэгдэж, улс төрийн өлсгөлөн хэзээ зогссон бэ? (1 оноо)  
А. 1990.3.23 В. 1990.3.9  
С. 1990.3.12 D. 1992.1.13 E. 1990.3.2



50. 1990 оны ардчилсан хувьсгал гарах болсон учир шалтгааныг зөв харгалзуулна уу. (2 оноо)

1. Гадаад шалтгаан      a. Шашин шүтэх, эс шүтэх эрхийг хааж байв.  
    b. ЗХУ-д өөрчлөн байгуулалт эхлэв.  
    c. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо ноёлж байв.
2. Дотоод шалтгаан      d. Социалист систем задарсан.

- A. 1c,d 2a,b                      B. 1a,c 2b,d  
 C. 1b,a 2c,d                      D. 1d,a 2c,b                      E. 1b,d 2a,c

51. Монгол улсын анхны ерөнхийлөгч хэн бэ? (1 оноо)

- A. Н.Энхбаяр      B. П.Очирбат      C. Ц.Элбэгдорж      D. Н.Багабанди      E. Х.Баттулга

52. 1992 оны Үндсэн хуулиар гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага аль нь вэ? (1 оноо)

- A. Ерөнхийлөгч                      B. Улсын Их Хурал                      C. Шүүх  
 D. Үндсэн хуулийн цэц                      E. Засгийн газар

53. Их Монгол улсаа тунхагласны 800 жилийн ой хэдэн онд тохиосон бэ? (1 оноо)

- A. 2006 он      B. 2002 он      C. 2022 он      D. 2009 он      E. 1990 он

54. Өгөгдлийг зөв тохируулна уу. (2 оноо)

a	1998 он	1	Монгол улсын түүх 5 боть нийтийн хүртээл болов.
b	1990 он	2	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг батлав.
c	2003 он	3	Монголын нууц товчооны 750 жилийн ойг тэмдэглэв.

- A. a2 b1 c3      B. a1 b2 c3      C. a3 b2 c1      D. a3 b1 c2      E. a2 b3 c1

55. 2012 онд Монгол улсын гадаад харилцаанд болсон онцлог үйл явдал аль нь вэ? (1 оноо)

- A. ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин айлчилсан.  
 B. БНХАУ-ын дарга Ши Жиньпин айлчилсан.  
 C. Япон улсын ерөнхий сайд Тошику Кайфу айлчилсан.  
 D. АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш айлчилсан.  
 E. НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга К.Аннан айлчилсан.

56. Үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын аль чиглэлд хамаарах вэ? (1 оноо)

- A. Хүний аюулгүй байдлыг хангах  
 B. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах  
 C. Дотоод аюулгүй байдлыг хангах  
 D. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах  
 E. Хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах



**ХОЁРДУГААР ХЭСЭГ**

**Санамж:** Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай тус бүр 6 оноотой. Нийт 24 оноо  
**Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай**

**2.1** Монгол нутагт оршиж байсан эртний улсуудын мөхсөн он цагийг зөв тохируулна уу. (6 оноо)

- |           |                      |
|-----------|----------------------|
| a. Хүннү  | 1. 1125              |
| b. Сяньби | 2. IX зууны I хагас  |
| c. Түрэг  | 3. 93                |
| d. Жужан  | 4. III зууны I хагас |
| e. Уйгур  | 5. 745               |
| f. Хятан  | 6. VI зууны II хагас |

**2.2** Монголын эзэнт гүрний түүхэнд холбогдох ойлголтыг зөв харгалзуулна уу. (6 оноо)

- |                  |   |
|------------------|---|
| a. Ил хаант улс  | 1. Мавераннахр, Могулистан                            |
| b. Кебек хан     | 2. Орос тэргүүтэй славян ба кипчак тэргүүтэй түрэгүүд |
| c. Их Юань улс   | 3. Нийт хүн амыг 4 зэрэглэлд хуваав                   |
| d. Цагадай       | 4. Цагадайн улс                                       |
| e. Марко Поло    | 5. Иран, Ирак, Азербайжан, Гүрж, Турк                 |
| f. Алтан орд улс | 6. Их Юань улс  |

**2.3** Түүхэн үйл явдлыг хамаарах он цагтай нь зөв тохируулна уу. (6 оноо)

- |   |         |
|---|---------|
| a. Алтан хан төвөд лам Содномжамцад “Далай лам” цол соёрхов.                | 1. 1586 |
| b. Дөчин, Дөрвөн хоёр “Их цааз” батлав.                                     | 2. 1639 |
| c. Абтай хан Эрдэнэзуу хийдийг байгуулав.                                   | 3. 1577 |
| d. Занабазарыг Анхдугаар Богдоор өргөмжлөв.                                 | 4. 1640 |
| e. Монголын улс төрийн төв эх нутагтаа шилжив.                              | 5. 1368 |
| f. Буйр нуурын ойролцоо Монгол, Мингийн их цэргийн хооронд тулалдаан болов. | 6. 1388 |

**2.4** Монголчуудын тусгаар тогтнолын төлөөх тэмцлийн арга хэлбэрүүдийг тохирох ойлголттой нь зөв харгалзуулна уу. (6 оноо)

- |                                   |                           |
|-----------------------------------|---------------------------|
| a. Тэмцлээ бичгээр илэрхийлэв     | 1. Дугуйлангийн хөдөлгөөн |
| b. Сөнөдийн Тэнгис ван ардын хамт | 2. Алба хаях              |
| c. Ордосын хошууд өрнөв           | 3. Ганц нэгээрээ тэмцэх   |
| d. 1755-1758 оны бослого          | 4. Бөөнөөрөө оргон нүүх   |
| e. Харуул, өртөө                  | 5. Заргын бичиг           |
| f. Шилийн сайн эрс                | 6. Зэвсэгт бослого        |

